



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Онцгой комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдөр зохион байгуулсугай.

2.Үйл ажиллагааны төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 795,600 (Долоон зуун ерэн таван мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3.Сургалтын бэлтгэл ажлыг сайтар ханган, чанар үр дүнтэй зохион байгуулахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 149 дугаар
захирамжийн хавсралт



СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төг)	Шаардагдах хэмжээ	Бүгд
1.	Багшийн хөлс	цаг	150,000	2	300,000
2.	Бичгийн цаас	ш	19,900	4	79,600
3.	Тоон гарын үсгийн төлбөр	ш	66,000	3	198,000
4.	Шатахууны зардал	л	2360	50	118,000
5.	Хоолны зардал	ш	20000	5	100,000
Бүгд					795,600